



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 14


Бор-Өндөр

**ОРОН НУТГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ОРОН НУТГИЙН
САНГИЙН ЖУРМЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмыг хавсралтаар баталсугай.
2. Орон нутгийн сангийн журмыг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга П.Чинбатад даалгасугай.
3. Тус журмыг холбогдох баримт бичгийн хамт захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга О.Сүхбаатарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хороо Б.Тулгад даалгасугай.

ДАРГА



ДОТГОНЦЭЦЭГ